

ХОЛБОГДОХ ЭРХ ЗҮЙН АКТЫН БИЕЛЭЛТ

Худалдан авах ажиллагааны газар

2016-07-01

(2016 оны эхний хагас жилийн байдлаар)

№	Эрх зүйн актын нэр, агуулга, огноо, дугаар: Заалт	Хэрэгжүүлэх байгууллага	Хяналтад байгаа заалтыг хэрэгжүүлэх талаар төлөвлөсөн арга хэмжээ	Хэрэгжилтийн явц, гарсан үр нөлөө	Хүчингүй болсон буюу хяналтаас хассан тухай тэмдэглэл/ өөрчлөлт оруулах тухай санал, дүгнэлт
A	1	2	3	4	5

Нэг. Улсын Их Хурлын тогтоол:

1	<p>Монгол Улсын 2016 оны төсвийн тухай хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай, 2015-12-03, Дугаар 108,</p> <p>Заалт 3:</p> <p>Эрүүл мэнд, боловсрол, цагдаа, онцгой байдал, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаас бусад салбарын бүх шатны төрийн байгууллагын ажил үүргийг оновчтой хуваарилах, чиг үүргийн давхардлыг арилгах, ажлын ачааллыг нягтруулах, төрийн үйлчилгээний зарим чиг үүргийг гэрээгээр гүйцэтгүүлэх, үүнтэй холбогдуулан ажлын цагийг уян хатан тогтоож үр дүнг цагаар тооцох, сул орон тоонд нөхөн томилгоо хийхгүй</p>	Засгийн газар	<p>2016 онд урсгал зардлыг бууруулахад чиглэсэн арга хэмжээг төлөвлөх,</p> <p>Төлөвлөсөн арга хэмжээг хэрэгжүүлэх замаар хэмнэлт бий болгож ажиллах.</p>	<p>Төрийн байгууллагын ажил үүргийг оновчтой хуваарилах, чиг үүргийн давхардлыг арилгах, ажлын ачааллыг нягтруулах, төрийн үйлчилгээний зарим чиг үүргийг гэрээгээр гүйцэтгүүлэхтэй холбоотойгоор үйлчилгээний 8 гэрээт ажилчныг 2015 оны 1 сараас эхлэн ажиллуулж эхэлсэн. 2016 оны эхний хагас жилийн байдлаар 23.1 сая төгрөгийн гэрээт ажилчны цалингийн зардал гарсан.</p> <p>Хагас жилийн төсвийн гүйцэтгэлийн тайлангаар урсгал зардалд аудит баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал, хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардал, ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшууллын зардал, мэдээлэл сурталчилгааны зардал нийт 21,7 сая төгрөгийн хэмнэлттэй гарав. Энэ нь улсын төсөв хүндрэлтэй байгаагаас шалтгаалан санхүүжилт орж ирээгүйтэй холбоотой хэмнэлт үүссэн байна. (ХШ-90%)</p>	
---	--	---------------	--	---	--

	байх зэргээр бүтээмжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн цогц арга хэмжээг хэрэгжүүлэх замаар цалингийн зардлын 10 хүртэл хувьтай тэнцэх хэмжээний урсгал зардлын хэмнэлт бий болгох;				
	УИХ-ын 1 тогтоолын 1 заалтын дүн:				Хэрэгжилтийн явц – 90,0 хувь: 90%-1.

Хоёр. Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг:

1	<p>“Нээлттэй хаалганы өдөр”-ийг зохион байгуулж байх тухай, 2007-05-24, Дугаар 97.</p> <p>Заалт 1:</p> <p>“БНМАУ-ын тусгаар тогтнолын талаархи асуудлын талаар бүх ард түмний саналыг гаргуулах тухай” БНМАУ-ын Бага хурлын Тэргүүлэгчдийн 1945 оны түүхэн шийдвэрийн дагуу Монгол Улсын тусгаар тогтнолыг баталгаажуулсан ард түмний санал асуулгыг явуулсан өдрийг тохиолдуулан Засгийн газар, орон нутгийн удирдлага, тэдгээрийн харъяаны бүх шатны байгууллага, албан тушаалтнууд бодлого боловсруулах, шийдвэр гаргахдаа иргэд, иргэний нийгмийн байгууллагуудын санал, зөвлөгөөг сонсч тусгах зорилгоор жил бүрийн 10 дугаар сарын 20-нд орон даяар “Нээлттэй хаалганы өдөр”-ийг зохион байгуулж ажиллах.</p>	Засгийн газар	<p>Байгууллагын үйл ажиллагааны жилийн төлөвлөгөөнд тусгах,</p> <p>Хэрэгжилтийг зохион байгуулах,</p> <p>Үр дүнг олон нийтэд мэдээлэх.</p>	<p>Худалдан авах ажиллагааны газар Нээлттэй өдөрлөгийг жилд 2 удаа зохион байгуулахаар 2016 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусган хэрэгжилтийг хангаж байна.</p> <p>2016 оны 03 сарын 15-ны өдөр Чингис хааны талбайд зохион байгуулагдсан “Олон улсын хэрэглэгчийн өдөр”-т зориулсан нээлттэй өдөрлөгийн арга хэмжээнд тус байгууллага идэвхитэй оролцон байгууллагын үйл ажиллагааг сурталчлан таниулж, хэрэглэгч, олон нийтэд мэдээлэл өгч, үйлчилгээ үзүүлэв. Нээлттэй өдөрлөгийн үеэр Худалдан авах ажиллагааны газраас иргэд, хэрэглэгчдэд хууль, эрх зүйн зөвлөгөө өгөх, худалдан авах ажиллагааны мэргэшүүлэх сургалтад 50 хувийн хөнгөлөлттэй үнээр бүртгэх, аж ахуйн нэгжүүдэд нууцлалын код өгөх, түүнчлэн 2015 онд Худалдан авах ажиллагааны газраас зохион байгуулсан тендер шалгаруулалтад амжилттай оролцож шалгарсан дотоодын үйлдвэрлэгчдийн төлөөлөл болох “Дархан нэхий” ХХК, “Амно” ХХК, “Зорбион” ХХК өөрсдийн үйлдвэрлэж, нийлүүлсэн бараа, бүтээгдэхүүнээ сурталчлах ажлыг зохион байгуулав. Мөн энэ үеэр Худалдан авах ажиллагааны чанар, хүртээмж, үр дүнгийн талаарх иргэдийн сэтгэл ханамжийг тодорхойлох судалгааг 50 гаруй иргэнээс авч, судалгааны дүнгийн дагуу иргэдэд чиглэсэн тодорхой ажлыг зохион байгуулан ажиллаж байна.</p> <p>Тайлант хугацаанд худалдан авах ажиллагаатай холбогдсон асуудлаар Засгийн газрын “11-11” төвд 11 санал, гомдол, шүүмжлэл ирснийг хүлээн авч, тухай бүр</p>	<p>Хэвшиж тогтмолжсон ажил тул хяналтаас хасуулах саналтай байна.</p> <p>Үндэслэл: ЗГ-ын 2013 оны 322 дугаар тогтоолоор баталсан “Захиргааны байгууллагын ХШҮ-ний нийтлэг журам”-ын 16 дугаар заалтын дагуу санал гаргасан.</p>
---	--	---------------	--	--	---

				<p>хариу өгсөн.</p> <p>Иргэдээс ирсэн санал, гомдол, хүсэлтийн төрөл: санал - 6, гомдол - 3, шүүмжлэл – 1, талархал – 1, нийт санал, хүсэлтийн 10 нь дуудлагаар, 1 саналыг цахим хуудсаар ирүүлсэн байна. “11-11” төвд худалдан авах ажиллагаатай холбогдсон асуудлаар ирсэн иргэдийн санал, гомдол, шүүмжлэлийг өнгөрсөн 2 жилийн мөн үеийн байдалтай харьцуулбал 15 хувиар буурсан байна.</p> <p>Цахим тендер шалгаруулалт зохион байгуулахаар цахим системд бүртгүүлэх захиалагч байгууллагын (давхардсан тоогоор) 25, хувийн нууцлалын код авах 52 өргөдлийг тус тус хүлээн авч, ажлын 3 хоногийн хугацаанд багтаан шийдвэрлэн, баталгаажуулж үйлчилсэн.</p> <p>2015 оны эхний хагаст 756 удаагийн тендер шалгаруулалтад 2531 ААН байгууллага оролцсон ба цахим худалдан авах ажиллагааны талаар иргэдээс 15 санал, хүсэлт, гомдол ирснээс 5 нь гомдол байсан бол 2016 оны 06 сарын 17-ны байдлаар, 1588 удаагийн тендер шалгаруулалтад 6403 ААН байгууллага оролцож, нийт 23 санал, хүсэлт, гомдол ирсний 8 нь гомдол байна. Гомдол өмнөх оны мөн үетэй харьцуулахад 63.3 хувиар багассан үзүүлэлттэй байна.</p> <p>“Цахим тендер шалгаруулалтын систем”-ийн үйл ажиллагаатай холбоотой санал, хүсэлтүүдийг нэгтгэн боловсруулж, “Цахим худалдан авах ажиллагааны системийн II үе шат” хөрөнгө оруулалтын төслийн гүйцэтгэлд шаардлага болгон тусгаж ажилласан.</p> <p>Санал, гомдлын хайрцгаар бүтээлч ажил, ажил хэрэгч санал ирүүлсэн тохиолдол гараагүй байна. (Б-100%)</p>	
	Ерөнхийлөгчийн 1 зарлигийн 1 заалтын дүн:			Хэрэгжилтийн явц – 100,0 хувь: 100%-1 заалт.	

Гурав. Үндэсний аюулгүй байдлын Зөвлөлийн зөвлөмж:

-	-	-	-	-
---	---	---	---	---

Дөрөв. Засгийн газрын тогтоол:				
1	<p>Захиргааны байгууллагын хяналт-шинжилгээ, үнэлгээний нийтлэг журам батлах тухай 2013-09-21, Дугаар 322</p> <p>Заалт 2:</p> <p>Энэхүү журмыг үндэслэн эрхэлсэн салбар, орон нутгийн онцлогт нийцсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний аргачлалыг боловсруулан баталж, мөрдүүлэх</p>	<p>Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлаг болон аймаг, нийслэлийн Засаг дарга нар</p>	<p>Үр дүнд суурилсан явцын үнэлгээ болон үр дүнд суурилсан ХШҮ хийх аргачлалыг боловсруулах, ХШҮ хийх төлөвлөгөө боловсруулан ажиллах, ХШҮ-ний аргачлалын дагуу гүйцэтгэл, үр дүнд хяналт, шинжилгээ, үнэлгээ хийж, дүгнэлт гаргах.</p>	<p>Дэлхийн банкны Олон салбарыг хамарсан техник тусалцааны төслийн Худалдан авах ажиллагааны газрын чадавхийг бэхжүүлэх дэд төслийн зөвлөх 2014 онд тус байгууллагад ажиллахдаа худалдан авах ажиллагааны газрын хэрэгжүүлж буй үйл ажиллагаа болон дотоод бүтцийн үйл ажиллагааны хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, дотоод аудит хийх, үр дүнд үнэлгээ өгөх, үйл ажиллагааг нэгдсэн удирдлагаар хангах, хариуцлагын нэгдсэн тогтолцоог төлөвшүүлэх, хууль тогтоомж зөрчихөөс урьдчилан сэргийлэх, ил тод байдлыг хангуулах, эрсдлийн удирдлага, зөвлөгөө мэдээллээр удирдлагыг хангах замаар агентлагийн үйл ажиллагааны үр өгөөжийг дээшлүүлэх талаар зөвлөмж, гарын авлага бэлтгэж гаргасныг үйл ажиллагааны үр дүн, гүйцэтгэлд хяналт тавихад ашиглаж байна. Мөн 2013 оны 04 сарын 08-ны өдрийн баталсан “Дотоод хяналт, шалгалтыг зохион байгуулах журам”-ыг барьж ажиллаж байна. (ХШ-70%)</p>
2	<p>Дотоодын үйлдвэрлэгчдийг дэмжих зарим арга хэмжээний тухай, 2014-01-28, Дугаар 18.</p> <p>Заалт 1:</p> <p>Худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа тендерийн баримт бичигт Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлд заасны дагуу дотоодын аж ахуйн нэгжүүдийн ирүүлсэн тендерийн Монгол Улсын гарал үүсэлтэй барааны хэсгийн үнийг 10 хувиар, ажил гүйцэтгэх тендерийн үнийг 7.5 хувиар хийсвэрээр бууруулж тооцон давуу эрх олгож ажиллах.</p> <p>Заалт 2:</p> <p>Тендерт оролцогчдод давуу эрх олгосон талаархи мэдээг худалдан</p>	<p>Төсвийн ерөнхийлөн захирагч нар, ХААГ</p>	<p>Мэдээг холбогдох дээд шатны байгууллагад хүргүүлэх арга хэмжээ авах</p>	<p>Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйл, Сангийн сайдын 2007 онд баталсан “Давуу эрх тооцох аргачлал” зэргийг мөрдлөг болгон ажиллаж байна. Давуу эрх тооцох аргачлалыг тодорхой болгох шаардлагатай байгаа тул 2007 онд Сангийн сайдын баталсан давуу эрх тооцох аргачлал бүхий журмыг шинэчлэн боловсруулахад ХААГ-аас саналаа тусгуулахаар Сангийн яаманд хүргүүлсэн.</p> <p>Давуу эрх тооцох тухай заалтыг тендерийн баримт бичигт тусган холбогдох хууль, тогтоомжийн заалтыг хэрэгжүүлэн ажиллаж байна. Тендерт оролцогч ААН-ээс тендер ирүүлэхдээ дотоодын давуу эрх тооцоулах хүсэлтээ гаргаж, холбогдох баримт, материалыг ирүүлсэн тохиолдолд давуу эрхийг холбогдох аргачлалын дагуу тооцон ажиллав. 2016 он гарсаар худалдан авах ажиллагаа зохион байгуулах явцад нийт 5 төсөл, арга хэмжээ (ажлын)-ний гүйцэтгэгчийн сонгон шалгаруулах худалдан авах ажиллагаанд оролцогч 6 ААН-ийн хүсэлтийн дагуу давуу эрхийн зөрүү тооцсон.</p>

	<p>авах ажиллагааны улирлын тайланд дэлгэрэнгүй тусган Сангийн яаманд тухай бүр хүргүүлж байх.</p>			<p>Харин бараа худалдан авах 1 төсөл, арга хэмжээний 8 багцын худалдан авалтад оролцогч (нийлүүлэгч) дотоодын үйлдвэрлэгч – 4 ААН-д давуу эрх олгосон.</p> <p>Худалдан авах ажиллагааны улирлын тайланд тусган мэдээлсэн. (ХШ-50%)</p>	
3	<p>Бүтэц, зохион байгуулалтын зардлын талаар авах зарим арга хэмжээний тухай, 2015-07-07, Дугаар 281.</p> <p>Заалт 1:</p> <p>1. Улсын Их Хурал, Засгийн газрын шийдвэрийн дагуу төсвийн зарим байгууллагад хийсэн бүтцийн өөрчлөлттэй холбогдон гарсан дараах зардалтай холбоотой асуудлыг эцэслэн шийдвэрлэхийг холбогдох төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгаж, шаардагдах хөрөнгийг 2015 оны улсын төсвийн зохих эх үүсвэрээс санхүүжүүлэхийг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга С.Баярцогт, Сангийн сайд Ж.Эрдэнэбат нарт зөвшөөрсүгэй: /Энэ заалтад ЗГ-ын 2015-8-31-ний өдрийн 350-р тогтоолоор өөрчлөлт орсон/ 1.1. цалин хөлс, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлын өр төлбөрийг барагдуулах, 1.2. байгууллага нь татан буугдсан, чиг үүрэг нь орон тооны хамт цомхотгогдсоны улмаас ажлаас чөлөөлөгдсөн төрийн албан хаагчдад хууль тогтоомжийн дагуу олгох нэг удаагийн тэтгэмжийн зардал; 1.3. бүтцийн өөрчлөлттэй холбогдох шийдвэрийн биелэлтийг зохион байгуулах үүрэг бүхий комисс, ажлын хэсгийн үйл ажиллагааны төсөвт тусгагдаагүй нэмэлт зардал, татан буугдсан буюу өөрчлөн байгуулагдсан байгууллагын архив, эд хогшлыг нүүлгэн шилжүүлэхэд гарсан</p>	<p>Холбогдох төсвийн ерөнхийлөн захирагч нарт</p>	<p>Холбогдох хууль, журамд заасны дагуу бүтцийн өөрчлөлттэй холбоотой хөрөнгийг зарцуулж, тайлагнах.</p>	<p>Монгол Улсын Засгийн газрын 2014 оны 387 дугаар тогтоолоор тус агентлагийн орон тооны хязгаарт өөрчлөлт орж, Шадар сайдын 2015 оны 01 сарын 07-ны өдрийн 03 дугаар тушаалаар агентлагийн үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр, зохион байгуулалтын бүтцийг шинэчлэн баталсан. Үүнтэй холбоотойгоор газрын даргын 2015 оны 02, 03 дугаар тушаал гарч, бүтцийн өөрчлөлтийг холбогдох хууль, тогтоомжийн хүрээнд хэрэгжүүлсэн. Тус байгууллага 65 орон тоотой, 2 дэд дарга, бүтцийн 8 нэгжтэйгээр ажиллаж байсан бол уг хөтөлбөрийн дагуу тус байгууллага 55 орон тоотой, 5 бүтцийн нэгжтэй, дэд даргагүйгээр, шинэчилсэн бүтэц, зохион байгуулалтаар ажиллаж байна.</p> <p>Бүтцийн өөрчлөлттэй холбоотой өөр өөрчлөлт, хөрөнгө зардал 2016 оны эхний хагас жилд гараагүй. (Б-100%)</p>	<p>Хугацаа дууссан, бүрэн хэрэгжсэн тул цаашид хяналтаас хасах саналтай байна.</p> <p>Үндэслэл: ЗГ-ын 2013 оны 322 дугаар тогтоолоор баталсан “Захиргааны байгууллагын ХШҮ-ний нийтлэг журам”-ын 16 дугаар заалтын дагуу санал гаргасан.</p>

	бусад зардал. Заалт 2: Энэ тогтоолын 1 дүгээр зүйлд заасан хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулж, хуульд заасны дагуу тайлагнах.				
4	Жагсаалт батлах тухай, 2015-08-17, Дугаар 336. Заалт 2: Дотоодын үйлдвэрээс худалдан авах чанар, стандартын шаардлага хангасан барааны жагсаалтад заасан барааг нийлүүлэх шаардлагыг тендерийн баримт бичигт тусгаж, жил бүрийн худалдан авахаар батлуулсан бараа, ажил, үйлчилгээний төлөвлөгөөний биелэлтийг дараа оны 1 дүгээр сард багтаан үйлдвэрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлж байх.	Төсвийн Ерөнхийлөн захирагч нарт	Зохион байгуулж байгаа худалдан авах ажиллагаанд мөрдөж, тендерийн баримт бичигт тусгах, Төлөвлөгөөний биелэлтийг холбогдох яаманд хүргүүлэх, Тогтоол, шийдвэрийн биелэлтийн тайлан, мэдээнд тусгах.	2015 онд 2,8 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий 5 төсөл, арга хэмжээний 39 багц ажлын тендер шалгаруулалтад дотоодын үйлдвэрлэгчийн бараа, бүтээгдэхүүнийг сонгосон. 2016 онд хэрэгжүүлэх 6,4 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий эм, эмнэлгийн хэрэгслийн 1 тендер шалгаруулалтын ажил 2015 оны 11 сард ЭМСЯ-аас эрх шилжиж ХААГ-т ирсэн. Энэхүү худалдан авах ажиллагааг зохион байгуулах Үнэлгээний хорооны бүрэлдэхүүнийг 2015 оны 11 сарын 18-ны өдрийн А/83 дугаар тушаалаар байгуулж, захиалагчаас ирүүлсэн техникийн тодорхойлолт, чанар, стандартын шаардлагыг үндэслэн тендерийн баримт бичгийг холбогдох хууль, тогтоомж, журам зааврын дагуу боловсруулан дотоодын давуу эрх тооцохоор тендерийн баримт бичигт тусгасан. Уг бараа нийлүүлэгчийг сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулах явцад 12 багц болон тендер зарлагдсан бөгөөд одоогийн байдлаар тэдгээрээс 8 багц ажилд дотоодын үйлдвэрлэгчийг дэмжиж, 4 ААН-д давуу эрх олгосон байна. (ХШ-70%)	
5	Жагсаалт батлах тухай, 2015-11-23, Дугаар 455. Заалт 2: Энэ тогтоолын хавсралтад заасан төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг шуурхай зохион байгуулан хэрэгжүүлэх, холбогдох зураг төсөл, техникийн тодорхойлолт, ажлын даалгаврыг хуулийн хугацаанд Худалдан авах ажиллагааны газарт	Худалдан авах ажиллагааны газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Х.Улам-Өрнөхөд, Төсвийн	Энэ тогтоолоор баталсан 43 төсөл, арга хэмжээний захиалагч - төсвийн ерөнхийлөн захирагч нартай хамтарсан төлөвлөгөө батлан хэрэгжүүлэх,	Засгийн газрын 2015 оны 455 дугаар тогтоолоор батлагдсан төсөл, арга хэмжээний жагсаалтын дагуу Улсын төсвийн хөрөнгө оруулалт болон Хөгжлийн банкны эх үүсвэрээр санхүүжигдэх нийт 73,0 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 43 төсөл, арга хэмжээ, мөн Төсвийн Ерөнхийлөн захирагч нараас эрх шилжиж ирсэн 19,3 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 13 төсөл, арга хэмжээ, Дэлхийн банкны санхүүжилтээр хэрэгжих 2,1 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий 4 төсөл, арга хэмжээ, нийт 94,4 тэрбум төгрөгийн төсөвтэй 60 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг ХААГ-т	

	хүргүүлэх.	ерөнхийлөн захирагч нарт.	<p>Худалдан авах ажиллагааны Ерөнхий төлөвлөгөөг Шадар сайдаар батлуулах,</p> <p>Захиалагчдаас зураг төсөл, ажлын даалгавар, техникийн тодорхойлолтыг шаардаж, худалдан авах ажиллагааг шуурхай зохион байгуулахад чиглэсэн арга хэмжээг авч хэрэгжүүлэх,</p> <p>Тендерийн урилга, зарыг нийтлэх өдөр тутмын сонины сонгон шалгаруулалтыг зохион байгуулах,</p> <p>Үнэлгээний хороодын гишүүдийг санамсаргүй сонголтын хэлбэрээр сонгон баталж, тендер шалгаруулалтыг зохион байгуулах.</p>	<p>холбогдох хууль, журмын дагуу 2016 онд зохион байгуулж байна.</p> <p>Эдгээр 60 төсөл, арга хэмжээ худалдан авах ажиллагааг зохион байгуулах явцад өнөөдрийн байдлаар нийт 120 багц болон задарч байгаа ба эдгээрийн худалдан авах ажиллагааны явцыг дор танилцуулбал:</p> <ol style="list-style-type: none"> 1. Гэрээ байгуулсан – 21, 2. Гэрээ байгуулах зөвлөмжийг захиалагчид хүргүүлсэн – 35, 3. Гэрээ байгуулах мэдэгдлийг оролцогчид хүргүүлсэн – 17, 4. Үнэлгээний тайлан, зөвлөмж бэлтгэж байгаа – 14, 5. Нээлт хийсэн, үнэлгээ хийж байгаа – 7, 6. Тендер зарласан, нээлт хийх хугацаа болоогүй байгаа – 5, 7. Дахин зарласан – 2, 8. Тендерийн баримт бичиг боловсруулж байгаа – 1, 9. ТЭЗ-аас зураг төсөл, техникийн тодорхойлолт, ажлын даалгавар ирүүлээгүй байгаа - 5 , 10. Баримт бичиг дутуу - 2, 11. Захиалагч (холбогдох ТЭЗ) жагсаалтаас хасуулсан, хасуулахаар бэлтгэж байгаа - 9, 12. Хүчингүй болсон мэдэгдлийг оролцогчдод хүргүүлсэн – 2. <p>2016 онд ХААГ-т зохион байгуулагдаж байгаа 60 төсөл, арга хэмжээний 120 багц ажлын худалдан авах ажиллагааны гүйцэтгэлийг дүгнэвэл,</p> <ul style="list-style-type: none"> ○ 60,8 хувь нь бүрэн хэрэгжсэн, ○ 25,8 хувь нь хэрэгжих шатанд буюу зохион байгуулагдаж байгаа, ○ 5,8 хувь нь захиалагч - Төсвийн Ерөнхийлөн захирагчаас тендер шалгаруулалтад шаардлагатай зураг төсөл, холбогдох материал ирүүлээгүй, хүлээгдэж байгаа, ○ 7,5 хувь нь ТЭЗ-ийн санаачилгаар хасагдсан 	
--	------------	---------------------------	---	---	--

				шалтгаанаар хэрэгжих боломжгүй байна. ХААГ-т зохион байгуулагдаж дууссан худалдан авах ажиллагааны үр дүнд (2016 оны 05 сарын 24-ний өдрийн байдлаар) улсын төсөвт 1,3 тэрбум төгрөгийн төсвийн хэмнэлт гарсан тооцоо гарч байна. (ХШ-70%)	
	5 тогтоолын 5 заалтын дүн:			Хэрэгжилтийн явц – 72,0 хувь: 100%-1, 70%-3, 50%-1 заалт.	

Тав. Засгийн газрын хуралдааны тэмдэглэл:

1	<p>Цахим худалдан авах ажиллагааны системийн өнөөгийн байдал цаашид хэрэгжүүлэх арга хэмжээ, төрийн байгууллага хоорондын уялдаа холбоог сайжруулах тухай, 2014-01-11, Дугаар 02</p> <p>Заалт XXII.1:</p> <p>Худалдан авах ажиллагааг цахим хэлбэрээр зохион байгуулах, цахим дэлгүүр ажиллуулах боломжийг бүрдүүлэх ажлын хүрээнд Нийтийн түлхүүрийн дэд бүтцийн программ хангамж, техникийн шийдэл, нөхцлийг ашиглан ЦХАА-ны системийг мэдээлэл солилцох төвлөрсөн сүлжээгээр дамжуулан УБЕГ, ШШГЕГ, НДЕГ-ын мэдээллийн системтэй холбох ажлыг зохион байгуулах</p>	<p>МТШХХГ, ХААГ, УБЕГ, ШШГЕГ, НДЕГ-ын дарга нар</p>	<p>Мэдээлэл солилцох төвлөрсөн сүлжээгээр дамжуулан мэдээлэл солилцох байгууллагуудтай уулзалт зохион байгуулах,</p> <p>хамтын ажиллагааны гэрээ байгуулан хэрэгжүүлэх ажлуудыг төлөвлөн ажиллаж байна.</p>	<p>“Цахим худалдан авах ажиллагааны системийн II үе шат” хөрөнгө оруулалтын төслийн хүрээнд цахим худалдан авах ажиллагааны нэгдсэн системийг ашиглалтад оруулахаар зорин ажилласны дүнд шинэ системийн технологийн ажлууд дууссан. 2016 оны 01 сарын 29-ний өдөр Шадар сайдын эрхлэх асуудлын хүрээний яам, агентлагуудын хэмжээнд зохион байгуулагдсан “Хэрэглэгчийн жил-2016”-ийн “Нэгэн дээвэр дор” нээлтийн арга хэмжээний үеэр Монгол Улсын Шадар сайд Ц.Оюунбаатар энэхүү шинэ системийн нээлтийн цанг цохиж, цахим худалдан авах ажиллагааны нэгдсэн системийг ашиглалтад хүлээн авав. 2016 онд энэхүү системээр дамжуулан төрийн худалдан авах ажиллагааг улсын хэмжээнд зохион байгуулах боломж бүрдээд байна. Системийн хөгжүүлэлтийг гүйцэтгэгч компани хийж байна.</p> <p>Уг нэгдсэн системийн боловсруулалтын хүрээнд “Мэдээлэл солилцоо” дэд системийн шийдлийг хийсэн бөгөөд энэхүү дэд системээр дараах төрийн байгууллага хоорондын мэдээлэл солилцооны шуурхай, бодит байдлыг ханган, тендер шалгаруулалтын ажилд ашиглаж байна. Тухайлбал, Улсын бүртгэл, статистикийн ерөнхий газраас Үндэсний Дата төвөөр дамжуулан УБСЕГ-ын Мэдээллийн нэгдсэн сангаас хуулийн этгээдийн талаарх мэдээллийг солилцох тухай № 14/30 тоот гэрээ байгуулан ажиллаж байна.</p> <p>Сангийн яамны “Санхүүгийн тайлангийн е-баланс” системээс хуулийн этгээдийн борлуулалтын орлого, түргэн хөрвөх чадвар, санхүүгийн тайлан зэргийн</p>	
---	--	---	---	--	--

				<p>талаарх мэдээллүүдийг солилцож байна.</p> <p>Цахим худалдан авах ажиллагааны нэгдсэн системийн “Мэдээлэл солилцоо” дэд системийг Гааль, татварын ерөнхий газрын системийн хуулийн этгээдийн мэдээллийн санд бүртгэгдсэн хэрэглэгчийн нэр, хувийн түлхүүрээ ашиглан ЦХАА-ны системд нэвтрэх боломжтой болгож, хуулийн этгээдийн татварын үлдэгдэл болон үйл ажиллагааны борлуулалтын орлого, автомашины лавлагааг авах талаарх мэдээллийг цахим хэлбэрээр солилцож байна.</p> <p>“Нийгмийн даатгалын шимтгэл төлөгчийн мэдээллийн сан хооронд мэдээлэл солилцох гэрээ”-г ХААГ-ын 1/88 тоот албан бичгээр 2016-03-10-ны өдөр Нийгмийн даатгалын ерөнхий газарт, “Татвар төлөгчдийн мэдээллийн сан хооронд мэдээлэл солилцох гэрээ”-г ХААГ-ын 1/89 тоот албан бичгээр 2016-03-10-ны өдөр Гааль, татварын ерөнхий газарт тус тус хүргүүлсэн боловч одоогоор албажаагүй, хүлээгдэж байна.</p> <p>Мөн Зам, тээврийн яамтай цахим тендерт оролцогч хуулийн этгээдийн машин механизмын бүртгэлийн талаарх мэдээлэл сорилцох хүсэлтийг 2016-06-10-ны өдрийн 1/735 тоот албан бичгээр хүргүүлээд байна.</p> <p>(ХШ-90%)</p>	
2	<p>Засгийн газрын 2010 оны 119 дүгээр тогтоолын хэрэгжилтийн тухай, 2015-01-07, Дугаар 01</p> <p>Заалт: XII.4.3:</p> <p>Шинээр гарсан хууль тогтоомжид нийцүүлэн захиргааны хэм хэмжээ тогтоосон шийдвэрт тухай бүр нэмэлт, өөрчлөлт оруулж байх,</p>	<p>Засгийн газрын гишүүд, бүх шатны Засаг дарга, Засгийн газрын агентлагийн дарга нарт</p>	<p>Эрх зүйн үндэслэлийг судлах,</p> <p>Тухайн бүр хэрэгжүүлэх.</p>	<p>Байгууллагын дотоодод батлан хэрэгжүүлж байгаа дүрэм, журмыг тухай бүр хууль тогтоомжид нийцүүлэх арга хэмжээ аван ажиллаж байна. Тухайлбал, Шилэн дансны тухай хууль, Үйлдвэрлэлийг дэмжих тухай хууль гарсантай холбогдуулан 2015 онд байгууллагын Хөдөлмөрийн дотоод журмыг шинэчлэн, ХААГ-ыг шилэн дансны мэдээлэл хөтлөх журмыг шинээр тус тус боловсруулан баталж, “Албан хэрэг хөтлөлт, архивын ажлын журам”, “Хөдөлмөрийн дотоод журам”-д нэмэлт, өөрчлөлт оруулан хэрэгжилтийг зохион байгуулан ажиллаж байна. 2016 оны эхний хагас жилд Байгууллагын Хөдөлмөрийн дотоод журамд зарим хууль, тогтоомжийн өөрчлөлттэй холбоотойгоор нэмэлт, өөрчлөлт оруулахаар хэлтэс, албан хаагчдаас санал</p>	

				авч, боловсруулаад байна. (Б-100%)	
	<p>Заалт: XII.4.4:</p> <p>Хуулиар тусгайлан эрх олгоогүй асуудлаар захиргааны хэм хэмжээ тогтоосон шийдвэр гаргахгүй байх.</p>	<p>Засгийн газрын гишүүд, бүх шатны Засаг дарга, Засгийн газрын агентлагийн дарга нарт</p>	<p>Эрх үндэслэлийг судлах,</p> <p>Мөрдөж ажиллах.</p>	<p>Хууль зүйн яамнаас зохион байгуулсан “Хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээ тогтоосон шийдвэрийг боловсронгуй болгох” уулзалт, сургалтад Хууль, хяналтын хэлтсийн мэргэжилтнийг оролцуулан, мэдлэг, мэдээллийг дээшлүүлэхэд анхааран ажиллав. Худалдан авах ажиллагаатай холбоотой захиргааны нийтлэг хэм хэмжээг тогтоосон эрх зүйн акт батлан гаргах эрх, үүрэг ХААГ-т байдаггүй болно. Ийм шийдвэр гараагүй.</p> <p>Захиргааны ерөнхий хууль, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль батлагдан, 2016.07.01-нээс хэрэгжиж эхлэхтэй холбогдуулан 2016.03.29-ний өдөр Хууль зүйн яамнаас зохион байгуулсан “Захиргааны ерөнхий хууль”-ийн сургалтад нийт албан хаагчдыг хамруулан энэ чиглэлээр тодорхой ойлголт, мэдлэгийг дээшлүүлсэн. Хуулиар тусгайлан эрх олгоогүй асуудлаар захиргааны хэм хэмжээ тогтоосон шийдвэрийг байгууллагын шийдвэр гаргах эрх бүхий албан тушаалтнаас гаргахгүй байх талаар албан хаагчдад мэдээлэл, зөвлөгөө өгч ажилласан.</p> <p>Хууль зүйн үндэсний төвөөс зохион байгуулсан Захиргааны эрх зүйн чиглэлээрх 2 кредитийн сургалтад холбогдох мэргэжилтнийг хамруулж, байгууллагын захиргааны эрх зүйн чадамжийг сайжруулахад анхааран ажиллав. (Б-100%)</p>	<p>Хэвшиж тогтмолжсон ажил тул хяналтаас хасуулах саналтай байна.</p> <p>Үндэслэл: ЗГ-ын 2013 оны 322 дугаар тогтоолоор баталсан “Захиргааны байгууллагын ХШҮ-ний нийтлэг журам”-ын 16 дугаар заалтын дагуу санал гаргасан.</p>
3	<p>Байгууллагын архив, албан хэрэг хөтлөлт, төрийн байгууллагын ажлын зохион байгуулалтын улсын үзлэгийн мөрөөр авах зарим арга хэмжээний тухай, 2016-02-01, Дугаар 07.</p> <p>Заалт XXIII.2:</p> <p>Байгууллагын нийт ажилтны ажлын байрны тодорхойлолт, үр дүнгийн гэрээ, хөдөлмөрийн гэрээнд албан хэрэг хөтлөлт, архивын ажлын талаар</p>	<p>Төрийн албаны зөвлөл, нийт байгууллагын удирдлага</p>	<p>Албан хаагчдын үр дүнгийн гэрээ, үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусган хэрэгжилтийг дүгнэх</p>	<p>Байгууллагын албан хаагчдын үр дүнгийн гэрээ, байгууллага, хэлтсийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд холбогдох заалтыг тусгуулах арга хэмжээ авч, 2016 оны албан хаагчдын үр дүнгийн гэрээг дүгнэхэд харгалзав. 2016 оны байгууллагын үйл ажиллагааны хөтөлбөрт уг асуудалтай холбоотой 3 арга хэмжээг төлөвлөн тусгасан бөгөөд эхний хагас жилийн байдлаар уг заалтуудын хэрэгжилт 96,7 хувийн гүйцэтгэлтэй хэрэгжсэн байна. (ХШ-90%)</p>	

	ажилтны хүлээх үүргийг тусгаж, гэрээг дүгнэхдээ харгалздаг байх чиглэлээр шаардлагатай арга хэмжээ авах				
4	<p>Монгол Улсын Засгийн газрын 2016-02-29-ний өдрийн хуралдааны тэмдэглэл, Дугаар 12.</p> <p>Заалт XXIII.2:</p> <p>Улсын төсвийн хөрөнгөөр худалдан авах бараа, ажил үйлчилгээний жагсаалт баталсан Засгийн газрын 2015 оны 336, Засгийн газрын 2015 оны 455 дугаар тогтоолуудын хэрэгжилтийн явцын талаар Монгол Улсын Шадар сайд Ц.Оюунбаатар Засгийн газрын гишүүдэд танилцуулав.</p> <p>Үүнтэй холбогдуулан 2016 онд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний ажлын зураг төсөл, техникийн тодорхойлолт, ажлын даалгавар, холбогдох бусад материалыг энэ оны 3 дугаар сарын 7-ны дотор багтаан Худалдан авах ажиллагааны газарт баталгаажуулан хүргүүлэх.</p>	ХААГ-т худалдан авалт нь зохион байгуулагдах төсөл, арга хэмжээний захиалагч (төсвийн ерөнхийлөн захирагч нар)	Захиалагчдад албан бичиг хүргүүлж, тендер шалгаруулалтад шаардлагатай холбогдох материалыг шуурхай ирүүлэхийг шаардах,	ЗГ-ын цахим хуралд мэдээлж, захиалагчдад үүрэг даалгавар өгүүлэх,	<p>2016 оны эхний хагас жилийн байдлаар Засгийн газрын 2015 оны 455 дугаар тогтоолоор баталсан, тус байгууллагад худалдан авалтыг зохион байгуулах 73,0 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий 43 төсөл, арга хэмжээнээс 36 төсөл, арга хэмжээний зураг төсөв, ажлын даалгавар, техникийн тодорхойлолтыг хүлээн авч худалдан авах ажиллагааны бэлтгэлийг 90,4 хувиар хангаснаар батлагдсан ажлуудын худалдан авах ажиллагаа зохион байгуулагдаж эхэлсэн.</p> <p>Мөн Төсвийн ерөнхийлөн захирагч нараас 19.3 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 13 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагаа тус байгууллагад эрх шилжиж ирсэнээс бүх төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагаанд шаардлагатай материалыг захиалагчаас хүлээн авч тендер шалгаруулалтыг зохион байгуулж байна. Гадаад эх үүсвэр буюу Дэлхийн банкны санхүүжилтээр хэрэгжих "Ухаалаг засаг" төслийн хүрээнд хэрэгжих 51 төсөл, арга хэмжээний жагсаалтыг хүлээн авч, тэдгээрээс холбогдох баримт материал ирүүлсэн байгаа 2,1 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий 4 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулж эхэлсэн байна.</p> <p>Захиалагчдад зураг төсөл, ажлын даалгавар, техникийн тодорхойлолтыг яаралтай ирүүлж, худалдан авах ажиллагааг шуурхай зохион байгуулах боломж, нөхцлөөр хангах талаар Шадар сайдаас 2 удаа, ХААГ-аас 2 удаа албан бичиг хүргүүлж, шаардлага тавин ажиллав. Засгийн газрын цахим хуралд 2 удаа мэдээлэл бэлтгэн өгч, худалдан авах ажиллагааны явцыг мэдээлэн, захиалагч нарт үүрэг, чиглэл өгүүлэх арга хэмжээ авч ажилласан.</p> <p>ХААГ-т нийт 94,4 тэрбум төгрөгийн төсөвтэй 60 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг холбогдох хууль, журмын дагуу 2016 онд зохион байгуулж байна. Эдгээр 60 төсөл, арга хэмжээ худалдан авах</p>

				ажиллагааг зохион байгуулах явцад өнөөдрийн байдлаар нийт 120 багц болон задарч байгаа ба 60,8 хувь нь бүрэн хэрэгжсэн, 25,8 хувь нь хэрэгжих шатанд буюу зохион байгуулагдаж байна. Харин 5,8 хувьд (7 төсөл, арга хэмжээ) нь захиалагч - Төсвийн Ерөнхийлөн захирагчаас тендер шалгаруулалтад шаардлагатай зураг төсөл, холбогдох материал ирүүлээгүй, хүлээгдэж байна, 7,5 хувь нь ТЕЗ-ийн санаачилгаар хасагдсан шалтгаанаар хэрэгжих боломжгүй болсон. (ХШ-90%)	
Заалт ХХIII.3: Хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийн хэрэгжилтийн 2015 оны жилийн эцсийн дүнгийн тухай. 1. Улсын Их Хурлын болон Байнгын хорооны тогтоол, Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн шийдвэр, Засгийн газрын шийдвэрээр Засгийн газар, сайд, Засгийн газрын агентлагийн дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасан заалт бүрийг хяналтад авч хэрэгжүүлэх ажлыг төлөвлөгөөний дагуу, шуурхай зохион байгуулах; 2. Үүрэг болгосон шийдвэрийн биелэлтийг тогтоосон хугацаанд “Засгийн газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний нэгдсэн систем” (www.unelgee.gov.mn)-д байршуулж, гарсан үр дүн, үр нөлөөг холбогдох зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн бодитойгоор хяналт-шинжилгээ хийж үнэлэн тайлагнах; 3. 2015 оны жилийн эцсийн байдлаар тасарсан болон хэрэгжилт нь удааширч байгаа үүрэг, даалгаврыг биелүүлэх талаар онцгой анхаарч,	Сайд, Засгийн газрын агентлагийн дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт	Заалтуудыг хэрэгжүүлж ажиллах зохион байгуулалтын арга хэмжээ авах, Хяналтад авсан шийдвэр, заалтуудын хэрэгжилтийг хангах, Хэрэгжилтэд мониторинг, үнэлгээ хийж, биелэлтийг тогтоосон хугацаанд мэдээлэх, Хэрэгжилтийг холбогдох цахим хуудсуудад байршуулан мэдээлэх.	2016 он гарсаар шинээр батлагдсан дээд шатны байгууллагын 10 шийдвэрийг хүлээн авч, удирдлагын мэдээллийн цогц систем www.able.mn дотоод сүлжээний холбогдох цэсэнд байршуулан нийт албан хаагчдад танилцуулан сурталчилж, хэрэгжилтийг зохион байгуулж эхлээд байна. 2016 оны эхний хагас жилийн байдлаар тус байгууллагад нийт 14 хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийн холбогдох 16 заалтыг хяналтад авч, хэрэгжилтийг зохион байгуулав. Тайлант хугацаанд, Засгийн газрын хяналт-шинжилгээ, үнэлгээ, мэдээллийн нэгдсэн систем www.unelgee.gov.mn -д хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийн 2015 оны жилийн эцсийн биелэлтийг заалт бүрээр оруулан, Засгийн газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээнд хамруулав. Засгийн газраас 95,91 хувийн гүйцэтгэлтэй гэж үнэлсэн. Тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийг байгууллагын удирдах ажилтны хуралд танилцуулан хэлэлцүүлж, цаашид хэрэгжилтийг эрчимжүүлэх талаар байгууллагын нэгж, хэлтсүүдэд үүрэг, чиглэл өгч, зохион байгуулалтаар ханган ажиллав. Дүн, мэдээг байгууллагын цахим хуудас болон дотоод сүлжээнд байршуулан олон нийт, байгууллагын албан хаагчдад мэдээлсэн. Худалдан авах ажиллагаатай холбоотой тогтоол, шийдвэрийн хэрэгжилтэд хамаарах худалдан авах ажиллагааны явцын мэдээллийг Засгийн газрын “Хэрэгжилт, хяналт, хариуцлага” цахим хуралд мэдээлэхээр 2 удаа мэдээлэл бэлтгэж, ЗГХЭГ-ын ХШДАГ-т хүргүүлэв. (ХШ-70%)		

	<p>хэрэгжсэн ажлыг Засгийн газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний нэгдсэн систем (www.unelgee.gov.mn)-д бүртгүүлж, хяналтаас хасуулах;</p> <p>4. Хуульд заасан эрх зүйн акт (дүрэм, журам, заавар, бусад)-ыг хугацаанд нь баталж мөрдүүлэх.</p>				
5	<p>“Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлого”-д тусгасан зорилт, арга хэмжээг 2015 онд хэрэгжүүлсэн явцын тухай. 2016.03.28, Дугаар 18.</p> <p>Заалт XIX.3:</p> <p>“Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал - 2030”-д тусгасан зорилт, арга хэмжээг цаашид хэрэгжүүлж ажиллах.</p>	<p>Сайд, Засгийн газрын агентлагийн дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт</p>	<p>Байгууллагын үйл ажиллагааг уг үзэл баримтлалтай уялдуулан төлөвлөж хэрэгжүүлэх</p>	<p>“Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал - 2030”-д тусгасан зорилт, арга хэмжээг цаашид салбарын болон байгууллагын хөгжлийн зорилттой уялдуулан хэрэгжүүлэх талаар анхаарч ажиллахаар байгууллагын нийт албан хаагчдад уг үзэл баримтлалыг сурталчлан таниулав. (ХШ-50%)</p>	
6	<p>Төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2015 оны худалдан авах ажиллагааны тайлан, хэрэгжилтэд хийсэн үнэлгээний дүнгийн тухай. 2016-04-04, Дугаар 20.</p> <p>Заалт XXIII.2:</p> <p>1. Илэрсэн зөрчил, дутагдлыг арилгаж, цаашид худалдан авах ажиллагааг холбогдох хууль, журам, зааврын дагуу хэрэгжүүлэх, 2015 оны үнэлгээгээр хангалтгүй дүн авсан албан тушаалтанд хариуцлага тооцож, дүнг 2016 оны 4 дүгээр сард багтаан Сангийн яаманд танилцуулах;</p> <p>2. “Дотоодын үйлдвэрлэгчдийг дэмжих зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2014 оны 1 дүгээр сарын 28-ны өдрийн 18 дугаар тогтоолын</p>	<p>Төсвийн ерөнхийлөн захирагч нарт</p>	<p>Үнэлгээний мөрөөр авах арга хэмжээг тодорхой болгож, хэлтсүүд сар, улирлын төлөвлөгөө, үйл ажиллагаандаа тусган хэрэгжүүлэх</p> <p>Худалдан авах ажиллагааны улирлын тайлангийн чанарыг сайжруулах.</p>	<p>Худалдан авах ажиллагааны тайлан, хэрэгжилтэд хийсэн үнэлгээгээр илэрсэн зөрчил, доголдлыг засах, тайлангийн чанарыг сайжруулж, холбогдох хууль, тогтоомж, журамд заасны дагуу боловсруулан мэдээлэх талаар арга хэмжээ авч, тайлан, мэдээллийг хариуцах нэгжийн үүргийг тодорхой болгов.</p> <p>Давуу эрх тооцох тухай заалтыг тендерийн баримт бичигт тусган холбогдох хууль, тогтоомжийн заалтыг хэрэгжүүлэн ажиллаж байна. Тендерт оролцогч ААН-ээс тендер ирүүлэхдээ дотоодын давуу эрх тооцуулах хүсэлтээ гаргаж, холбогдох баримт, материалыг ирүүлсэн тохиолдолд давуу эрхийг холбогдох аргачлалын дагуу тооцон ажиллав. 2016 он гарсаар худалдан авах ажиллагаа зохион байгуулах явцад нийт 5 төсөл, арга хэмжээ (ажлын)-ний гүйцэтгэгчийн сонгон шалгаруулах худалдан авах ажиллагаанд оролцогч 6 ААН-ийн хүсэлтийн дагуу давуу эрхийн зөрүү тооцсон. Харин бараа худалдан авах 1 төсөл, арга хэмжээний 8</p>	

	<p>хэрэгжилтийг ханган ажиллаж, худалдан авах ажиллагааны улирлын тайланг нэгтгэн Сангийн яаманд хүргүүлж байх;</p> <p>3. Монгол Улсын төсвийн тухай хуулиар баталсан урсгал төсвийн болон хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хүрээнд бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тендерийг 2016 оны 5 дугаар сарын 1-ний өдрийн дотор зарлан, мөн оны 6 дугаар сарын 15-ны өдрийн дотор тендер шалгаруулалтыг зохион байгуулж дуусган, гүйцэтгэгчтэй гэрээ байгуулж, ажлыг эхлүүлсэн байх;</p> <p>4. Тендер шалгаруулалтын урилгыг олон нийтэд зарлан мэдээлэхдээ оролцогч аж ахуйн нэгжүүд Засгийн газрын бондоор тендерийн баталгаа гаргах боломжийг бүрдүүлэн ажиллах.</p>			<p>багцын худалдан авалтад оролцогч (нийлүүлэгч) дотоодын үйлдвэрлэгч – 4 ААН-д давуу эрх олгосон. Худалдан авах ажиллагааны 2016 оны эхний хагас жилийн тайланг Сангийн яаманд 2016-07-01-ний өдрийн 1/952 дугаар албан бичгээр хүргүүлэв.</p> <p>2016 онд ХААГ-т зохион байгуулагдаж байгаа 60 төсөл, арга хэмжээний 120 багц ажлын худалдан авах ажиллагааны гүйцэтгэлийг 2016 оны эхний хагас жилийн байдлаар дүгнэвэл,</p> <ul style="list-style-type: none"> ○ 60,8 хувь нь бүрэн хэрэгжсэн, ○ 25,8 хувь нь хэрэгжих шатанд буюу зохион байгуулагдаж байгаа, ○ 5,8 хувь нь захиалагч - Төсвийн Ерөнхийлөн захирагчаас тендер шалгаруулалтад шаардлагатай зураг төсөл, холбогдох материал ирүүлээгүй, хүлээгдэж байгаа, ○ 7,5 хувь нь ТЕЗ-ийн санаачилгаар хасагдсан шалтгаанаар хэрэгжих боломжгүй байна. <p>Тендер шалгаруулалт нь бүрэн дууссан ажлуудын гүйцэтгэгч, нийлүүлэгчтэй захиалагч (Төсвийн ерөнхийлөн захирагч) нь гэрээ байгуулан ажлыг эхлүүлнэ. (ХШ-70%)</p>	
7	<p>Үндэсний хөтөлбөрүүдийг 2015 онд хэрэгжүүлсэн байдалд ХШҮ хийсэн дүнгийн тухай, 2016-05-31,</p> <p>Дугаар 30.</p> <p>Заалт ХХҮ.2:</p> <p>1. УИХ, Засгийн газрын тогтоолоор баталсан хэрэгжилт нь хангалтгүй байгаа Үндэсний хөтөлбөрүүдийн жагсаалтыг гаргаж, холбогдох тайлбар, танилцуулгын хамт 2016 оны III улиралд багтаан ЗГХЭГ-т ирүүлэх,</p> <p>2. Салбарын хэмжээнд зорилго, зорилтууд нь давхцаж байгаа үндэсний хөтөлбөрүүдийг шинэчлэх,</p>	<p>Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлагийн дарга нарт</p>	<p>Үндэсний хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг эрчимжүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэх,</p> <p>Хөтөлбөрүүдийг хэрэгжилтийг тооцож, мэдээлэх.</p>	<p>Үндэсний хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх ажлыг эрчимжүүлэх талаар байгууллагын үйл ажиллагаанд анхааран ажиллаж байна. Хэрэгжүүлэх ажлуудыг байгууллагын үйл ажиллагааны улирлын төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлэх арга хэмжээ авч ажиллав. (ХШ-30%)</p>	

нэгтгэх, тухайн онд хэрэгжиж дуусах хөтөлбөрийн хэрэгжилтэд үнэлгээ өгч, Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хуульд заасны дагуу цашид авах арга хэмжээний талаар санал боловсруулж, 2016 оны III улиралд багтаан Засгийн газрын хуралдаанд танилцуулах.				
7 тэмдэглэлийн 9 заалтын дүн:			Хэрэгжилтийн явц – 76,7 хувь: 100%-2, 90%-3, 70%-2, 50%-1, 30%-1.	

ХОЛБОГДОХ ЭРХ ЗҮЙН АКТЫН ХЭРЭГЖИЛТИЙН ТОВЧ ДҮН (нэр төрлөөр)

(2016 оны эхний хагас жилийн дүнгээр)

№	Холбогдох эрх зүйн акт		Хэрэгжилтийг тооцсон заалт	Хэрэгжилтийн явц (хувь)
	Нэр төрөл	Тоо		
1	УИХ-ын тогтоол	1	1	90,0
2	Ерөнхийлөгчийн зарлиг	1	1	100,0
3	Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмж	-	-	-
4	Засгийн газрын тогтоол	5	5	72,0
5	Ерөнхий сайдын захирамж	-	-	-
6	Засгийн газрын хуралдааны тэмдэглэл	7	9	76,7
ХОЛБОГДОХ ЭРХ ЗҮЙН АКТЫН ХЭРЭГЖИЛТИЙН ДҮН		14	16	77,5

ХЭРЭГЖИЛТИЙН ЯВЦ (нийт заалтаар)

Д/д	Хэрэгжилтийн явц (Нийт заалтаар)	Заалтын тоо
1	Нийт хэрэгжүүлэх заалт	16
2	Бүрэн хэрэгжиж биелсэн – (Б.)	4
3	Хэрэгжих шатандаа – (ХШ.)	12
	Үүнээс: 90%	4
	70%	5
	50%	2
	30%	1
	10%	-
4	Хэрэгжүүлэх хугацаа болоогүй хүлээгдэж байгаа - (ХБ.)	-
5	Тасарсан – (Т.)	-
6	Хэрэгжилтийн хувь	77,5

ТАНИЛЦСАН:
ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ГАЗРЫН ДАРГЫН
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Н.ОТГОНБАЯР

ХЯНАСАН:
ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ГАЗРЫН
ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Ч.ЖАРГАЛАН

БОЛОВСРУУЛСАН:
ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН

Х.ЭНХЧИМЭГ